



“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-Т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: 26 32 25, Факс: (976-11) 32 00 41,

Цахим шуудан: contact@ama.gov.mn,

Цахим хуудас: www.ama.gov.mn

2024.11.08 № 01/1865

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Тендерийн баримт бичигт  
өөрчлөлт оруулах тухай**

Танай газраас зарласан “Ажиллагсдад олгох хүнсний нэмэлт бүтээгдэхүүн” МРЦМ/20240102280 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Сайн шүтээн” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж, 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/1715 дугаартай албан бичгээр тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулахыг даалгасан.

Гэвч танай газраас тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн зарлахдаа тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулаагүй байна.


Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/253 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 1.3-т “Гомдол хянан шийдвэрлэх байгууллагын шийдвэрийг захиалагч Захиргааны ерөнхий хуулийн 98.2-т заасны дагуу заавал биелүүлнэ” гэж; Захиргааны ерөнхий хуулийн 98 дугаар зүйлийн 98.2-т “Энэ хуулийн 98.1-д заасан захиргааны актыг холбогдох захиргааны байгууллага заавал биелүүлнэ” гэж тус тус заасан байна.

Иймд Монополын эсрэг газраас танай байгууллагад хүргүүлсэн 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/1715 дугаартай албан бичигт заасны дагуу “Тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтын 1 дэх шалгуур үзүүлэлтэд холбогдох өөрчлөлт оруулахыг үүгээр дахин даалгаж байна.

Захиалагч нь холбогдох өөрчлөлт оруулахгүй, тендер шалгаруулалтыг нээсэн тохиолдолд хуулийн дагуу холбогдох газарт шилжүүлэхийг анхаарна уу.

Хувийг “Сайн шүтээн” ХХК-д хүргүүлэв.

ДАРГА



Б.БИЛГҮҮН

0000682